

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хэнтий аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/21/НА-СТА-ТШЗ**

---

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 93032714

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

---

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт.....	14
.....	14
4.3 Албан шаардлага .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

᠘᠒᠘ - ᠐3 - ᠐4 № 88  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030130

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>20,786,098.50</b>	<b>24,393,294.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>5,400,000.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	<b>5,400,000.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	<b>5,400,000.00</b>
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	5,400,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	<b>46,938.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	46,938.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>6,000,000.00</b>	-
34600	Урьдчилж гарсан зардал	6,000,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>12,649,806.00</b>	<b>18,946,356.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>12,649,806.00</b>	<b>18,946,356.00</b>
35420	Аж ахуйн материал	8,797,630.00	13,324,180.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,290,000.00	1,631,000.00
35440	Түлш, шатах тослох материал	456,000.00	1,585,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,106,176.00	2,406,176.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>2,136,292.50</b>	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	2,136,292.50	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>263,683,378.51</b>	<b>280,029,211.12</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>263,683,378.51</b>	<b>280,029,211.12</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>170,955,044.97</b>	<b>188,208,877.50</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	154,679,090.00	154,679,090.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,000,835.88)	(47,903,624.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,821,075.00	69,821,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(39,487,741.69)	(45,087,741.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,719,994.20	134,274,724.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(68,897,867.04)	(78,999,653.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,843,153.24	14,843,153.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,721,822.86)	(13,418,145.65)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>92,728,333.54</b>	<b>91,820,333.62</b>
39301	Програм хангамж	5,480,000.00	5,930,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,986,666.56)	(4,256,666.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	90,455,000.00	90,455,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(219,999.90)	(307,999.86)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>284,469,477.01</b>	<b>304,422,505.12</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>53,059.80</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>53,059.80</b>	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>53,059.80</b>	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	53,059.80	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>284,416,417.21</b>	<b>304,422,505.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>284,416,417.21</b>	<b>304,422,505.12</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>304,138,413.00</b>	<b>304,138,413.00</b>
51101	Өмч: - төрийн	304,138,413.00	304,138,413.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(57,274,452.10)</b>	<b>(37,268,364.19)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(57,274,452.10)	(57,274,452.10)
51220	Тайлант үеийн үр дүн	-	20,006,087.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37,552,456.31	37,552,456.31
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>284,469,477.01</b>	<b>304,422,505.12</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,352,149,841.74</b>	<b>2,128,824,706.53</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>108,161,388.74</b>	<b>119,328,601.53</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>108,161,388.74</b>	<b>119,328,601.53</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	108,161,388.74	119,328,601.53
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	108,161,388.74	119,328,601.53
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,243,988,453.00</b>	<b>2,009,496,105.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,206,868,800.00	1,752,270,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,206,868,800.00	1,752,270,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,119,653.00	257,225,405.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,650,000.00	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,332,138.00	226,693,305.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,137,515.00	24,532,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,344,360,201.12</b>	<b>2,108,818,618.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,344,360,201.12</b>	<b>2,108,818,618.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>645,704,191.47</b>	<b>711,791,364.14</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,378,589.00	258,515,254.00
210101	Үндсэн цалин	156,225,995.00	168,452,639.00
210102	Нэмэгдэл	44,368,805.00	36,837,151.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,160,000.00	29,136,000.00
210104	Урамшуулал	5,623,789.00	8,891,279.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	15,198,185.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,194,039.44	32,962,577.04
210201	Тэтгэврийн даатгал	21,001,098.17	23,152,561.42
210202	Тэтгэмжийн даатгал	2,441,934.36	2,580,167.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,898,560.29	2,023,818.91
210204	Ажилгүйдлийн даатгал	441,130.14	473,275.03
210205	Эрүүл мэндийн даатгал	4,411,316.48	4,732,754.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,397,918.65	15,719,261.56
210301	Гэрэл, цахилгаан	1,306,687.65	947,141.56
210302	Түлш, халаалт	13,608,716.00	14,501,850.00
210303	Цэвэр, бохир ус	482,515.00	270,270.00
2104	Хангамж, бараа материалын зардал	277,009,390.84	152,633,780.15
210401	Бичиг хэрэг	585,120.00	9,072,865.00
210402	Тээвэр, шатахуун	3,653,850.00	3,655,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	408,859.80	409,801.12
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	264,000.00	16,354,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	469,150.00	3,437,330.00
210408	Бараа материал акталсны зардал	5,628,364.80	-
210409	Бараа материал шилжүүлсний зардал	266,000,046.24	119,704,094.03
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	610,450.00	7,373,100.00
210604	Урсгал засвар	610,450.00	7,373,100.00
2107	Томиллолт, зочны зардал	1,358,200.00	4,469,900.00
210702	Дотоод албан томиллолт	1,358,200.00	4,469,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,143,891.26	162,370,284.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,143,891.26	162,370,284.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,611,712.28	77,747,207.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,423,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,998,363.00	37,664,860.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,613,349.28	29,658,897.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,698,656,009.65</b>	<b>1,397,027,254.48</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,584,674,630.00	1,152,318,560.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	864,265,026.00	467,737,304.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	713,840,604.00	684,131,256.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,569,000.00	450,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>113,981,379.65</b>	<b>244,708,694.48</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,922,717.65	243,627,824.48
213305	Нэмэлт санхүүжилтт төвлөрүүлэх шилжүүлэг	2,058,662.00	1,080,870.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>7,789,640.62</b>	<b>20,006,087.91</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>7,789,640.62</b>	<b>20,006,087.91</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,251,273,003.00</b>	<b>2,009,496,105.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,251,273,003.00</b>	<b>2,009,496,105.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,206,868,800.00</b>	<b>1,752,270,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,206,868,800.00	1,752,270,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>44,404,203.00</b>	<b>257,225,405.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,650,000.00	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,332,138.00	226,693,305.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,422,065.00	24,532,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,249,218,203.00</b>	<b>1,965,702,175.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,249,218,203.00</b>	<b>1,965,702,175.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>550,562,193.35</b>	<b>568,674,920.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>237,378,589.00</b>	<b>258,562,192.00</b>
210101	Үндсэн цалин	165,520,594.00	168,452,639.00
210102	Нэмэгдэл	48,600,405.00	36,837,161.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,599,970.00	29,135,990.00
210104	Урамшуулал	5,657,620.00	8,891,279.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	15,245,123.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,542,652.70</b>	<b>32,962,577.04</b>
210201	Тэтгэрийн даатгал	21,349,711.43	23,152,562.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,441,934.36	2,580,165.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,898,560.29	2,023,819.22
210204	Ажилгүйдлийн даатгал	441,130.14	473,275.44
210205	Эрүүл мэндийн даатгал	4,411,316.48	4,732,754.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,397,918.65</b>	<b>15,719,261.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,306,687.65	947,141.56
210302	Түлш, халаалт	13,608,716.00	14,501,850.00
210303	Цэвэр, бохир ус	482,515.00	270,270.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,452,720.00</b>	<b>37,150,705.92</b>
210401	Бичиг хэрэг	502,370.00	8,850,425.00
210402	Тээвэр, шатахуун	3,525,850.00	4,784,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	355,800.00	462,860.92
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	264,000.00	16,354,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,804,700.00	6,698,730.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>180,084,450.00</b>	<b>8,065,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	179,284,000.00	75,900.00
210604	Урсгал засвар	800,450.00	7,990,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,358,200.00</b>	<b>4,469,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,358,200.00	4,469,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>38,695,278.00</b>	<b>162,370,284.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,695,278.00	162,370,284.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,652,385.00</b>	<b>49,374,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,423,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,652,385.00	38,950,650.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,698,656,009.65</b>	<b>1,397,027,254.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,584,674,630.00</b>	<b>1,152,318,560.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	864,265,026.00	467,737,304.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	713,840,604.00	684,131,256.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,569,000.00	450,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>113,981,379.65</b>	<b>244,708,694.48</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,922,717.65	243,627,824.48
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	2,058,662.00	1,080,870.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,054,800.00</b>	<b>43,793,930.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,054,800.00</b>	<b>38,393,930.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,054,800.00</b>	<b>38,393,930.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,054,800.00</b>	<b>38,393,930.00</b>
223001	Бусад хөрөнгө	2,054,800.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	38,393,930.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,054,800.00)</b>	<b>(38,393,930.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>5,400,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>5,400,000.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>304,138,413.00</b>	<b>37,552,456.31</b>	<b>(65,064,092.72)</b>	-	<b>276,626,776.59</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,138,413.00	37,552,456.31	(65,064,092.72)	-	276,626,776.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	7,789,640.62	-	7,789,640.62
<b>C08</b>	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>304,138,413.00</b>	<b>37,552,456.31</b>	<b>(57,274,452.10)</b>	-	<b>284,416,417.21</b>
<b>D01</b>	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>304,138,413.00</b>	<b>37,552,456.31</b>	<b>(57,274,452.10)</b>	-	<b>284,416,417.21</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	304,138,413.00	37,552,456.31	(57,274,452.10)	-	284,416,417.21
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	304,138,413.00	37,552,456.31	(57,274,452.10)	-	284,416,417.21
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	20,006,087.91	-	20,006,087.91
<b>D09</b>	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>304,138,413.00</b>	<b>37,552,456.31</b>	<b>(37,268,364.19)</b>	-	<b>304,422,505.12</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,752,270,700.00</b>	<b>1,508,642,875.52</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,752,270,700.00</b>	<b>1,508,642,875.52</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>448,020,900.00</b>	<b>356,324,315.52</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>272,816,900.00</b>	<b>258,562,192.00</b>
210101	Үндсэн цалин	194,000,500.00	168,452,639.00
210102	Нэмэгдэл	49,983,300.00	36,837,161.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9504000.00	29135990.00
210104	Урамшуулал	4014000.00	8891279.00
210105	Гэрээт ажлын хөлс	15315100.00	15245123.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,830,100.00</b>	<b>32,962,577.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,717,500.00	23,152,562.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,528,200.00	2,580,165.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,022,500.00	2,023,819.22
210204	Ажилгүйдлийн даатгал	505,600.00	473,275.44
210205	Эрүүл мэндийн даатгал	5,056,300.00	4,732,754.64
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,225,200.00</b>	<b>15,719,261.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,572,100.00	947,141.56
210302	Түлш, халаалт	14,205,900.00	14,501,850.00
210303	Цэвэр, бохир ус	447200.00	270270.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,577,200.00</b>	<b>9,692,440.92</b>
210401	Бичиг хэрэг	340,300.00	351,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,616,000.00	2,536,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	302,500.00	462,860.92
210404	Ном, хэвлэл	131,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	224,400.00	264,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,963,000.00	6,078,480.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>87,110,200.00</b>	<b>23,209,930.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	79,120,200.00	15,219,930.00
210604	Урсгал засвар	7,990,000.00	7,990,000.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>298,200.00</b>	<b>298,200.00</b>
210702	Дотоод албан томиллолт	298,200.00	298,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,843,100.00</b>	<b>5,561,264.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,843,100.00	5,561,264.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,320,000.00</b>	<b>10,318,450.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,320,000.00	10,318,450.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,304,249,800.00</b>	<b>1,152,318,560.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,304,249,800.00</b>	<b>1,152,318,560.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	607,041,100.00	467,737,304.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	696,753,300.00	684,131,256.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	455,400.00	450,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,752,270,700.00</b>	<b>1,508,642,875.52</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,752,270,700.00</b>	<b>1,508,642,875.52</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,752,270,700.00	1,508,642,875.52

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>251,825,405.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>250,744,535.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>250,744,535.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,458,265.00</b>
210401	Бичиг хэрэг	8,499,325.00
210402	Тээвэр, шатахуун	2,248,690.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,090,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	620,250.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,799,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,799,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,171,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,171,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>156,809,020.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,809,020.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,505,650.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,423,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,082,200.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,080,870.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,080,870.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>257,225,405.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>257,225,405.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	226,693,305.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,532,100.00
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,400,000.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт нь багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг ханган хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, эх оронч сэтгэлгээтэй насан туршдаа хөгжих чадвартай зөв Монгол иргэн бэлтгэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

БСШУЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс 2021 онд аймгийн Боловсролын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,105.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 21.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Тайлант онд нийт зардал буурсан учраас материаллаг байдлыг гүйцэтгэлийн үед 15.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Боловсролын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	5.4	(5.4)
Авлага	-	0.0	(0.0)
Урьдчилгаа	6.0	-	6.0
Бараа материал	12.6	18.9	(6.3)
Үндсэн хөрөнгө	263.7	280.0	(16.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>282.3</b>	<b>304.4</b>	<b>(22.1)</b>
Өр төлбөр	0.1	-	0.1
Засгийн газрын оролцоо	284.4	304.4	(20.0)
Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/	304.1	304.1	-
Өмнөх үеийн үр дүн	(57.3)	(57.3)	-
Тайлант үеийн үр дүн	-	20.0	(20.0)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37.6	37.6	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>284.5</b>	<b>304.4</b>	<b>(20.0)</b>

Мөнгөн хөрөнгө нь ахмадын сангийн үлдэгдэл 5.4 сая төгрөгөөр өсжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 6.3 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16.3 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 6.0 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран зохион байгуулсан “Янзган хүрээг хайрлаарай” цахим уралдаан зохион байгуулж, уралдаанд шалгарсан материалаар гарын авлага хэвлүүлэхээр 2020 оны эцэст урьдчилж төлсөн авлага тайлант онд гарын авлагыг бүрэн авч авлага барагджээ. Мөн өр төлбөр дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 304.4 сая төгрөг болж, тайлант үеийн үр дүнгийн 20.0 сая төгрөгөөр өссөн.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 228.7 сая төгрөгөөр буюу 9.7 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс санхүүжилт, материаллаг өөрчлөлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 240.9 сая төгрөгөөр буюу 10.3 хувиар буурсан нь хангамж, бараа материалын зардал, урсгал шилжүүлэг буурсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 509.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,243.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,752.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь аймгийн ЕБС, цэцэрлэгийн урсгал шилжүүлгийн тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг нэмэгдэж батлагдсантай холбоотой.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг улсын төсвөөс 1,752.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,752.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,508.6 сая төгрөг зарцуулж, 243.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 226.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 25.1 сая төгрөг нийт 251.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 250.7 сая төгрөгийг зарцуулж, 1.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас 23.7 сая төгрөгийг сургалтын багшийн хөлс, томилолт, хоол, цайны зардал, бичиг хэргийн материалд, 10.5 сая төгрөгийг ойн арга

хэмжээ, хоолонд, 185.5 сая төгрөгийг сумдын сургууль, цэцэрлэгийн ариутгал, бичиг хэргийн материал, “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн санхүүжилтэд, 6.0 сая төгрөгийг төслийн ажлын мониторинг хийх зардалд, 3.0 сая төгрөгийг сургуулиудын химийн хортой, шатамхай, тэсрэмтгий бодис устгахад, 20.9 сая төгрөгийг аймгийн Боловсролын газрын Контент боловсруулах лаборатори байгуулахад, ариутгал хийхэд, элсэлтийн ерөнхий шалгалтын тэмдэг тэмдэглэгээ хэвлүүлэхэд, 1.1 сая төгрөгийг хүүхэд асрах үйлчилгээнд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцлох асуудал байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг шалгахад 49.7 сая төгрөгийн 3 худалдан авалтыг, 2,034.3 сая төгрөгийн 29 орлогын, 123.0 сая төгрөгийн 12 зарлагын мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ИТХ, Засаг дарга, төсөл хэрэгжүүлэгч нараас олгосон санхүүжилтийг танхимын сургалт зохион байгуулахад багшийн хөлс, томилолт, буудлын үнэ, сургалтын хоол цай, бичиг хэргийн материал, шатахуун зэрэгт зарцуулж байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, хандив авахгүй байх 2 зөвлөмж өгөгдсөн нь бүрэн биелжээ.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг үндсэн хөрөнгө тус бүрээр авч үзэх болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 46.0 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 45.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлсэн.

### **4.1 Залруулсан алдаа**

Залруулга хийгдээгүй.

### **4.2 Төлбөрийн акт**

Томилолтоор ажилласан ажлын хоногт 0.6 сая төгрөгийн хоолны хөнгөлөлт давхардуулан олгосон байна.

### **4.3 Албан шаардлага**

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллыг зөрчин 3.8 сая төгрөг зарцуулсан.

Байгууллагын дарга өөрийн нөхрийг байгууллагын жолоочийн албан тушаалд 2021 оны 11 дүгээр сард томилж, 2.0 сая төгрөгийн цалин, томилолт олгосон.

Сургалтыг танхимаар зохион байгуулж 24.7 сая төгрөг, ойн арга хэмжээ зохион байгуулж 9.5 сая төгрөг нийт 34.2 сая төгрөг зарцуулсан.

Ахмадын санд төлөвлөгдөөгүй 5.4 сая төгрөг шилжүүлсэн.

### **4.4 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Боловсролын газар	4	11.8			1	0,6	3	11.2		
<b>ДҮН</b>		<b>4</b>	<b>11.8</b>			<b>1</b>	<b>0.6</b>	<b>3</b>	<b>11.2</b>		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хэнтий аймгийн Боловсролын газар	1	34.2					1	34.2		
<b>ДҮН</b>		<b>1</b>	<b>34.2</b>					<b>1</b>	<b>34.2</b>		
<b>НИЙТ ДҮН</b>		<b>5</b>	<b>46.0</b>			<b>1</b>	<b>0.6</b>	<b>4</b>	<b>45.4</b>		

  
**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ**

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 07

Чингис хот

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтоор ажилласан хугацаанд 0.6 сая төгрөгийн хоолны мөнгө давхардуулан олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ.", 2.2.1-т "унааны зардал", 2.2.2-т "байрны зардал", 2.2.3. "хоолны зардал" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Давхардуулан олгосон 600.0 мянган төгрөгийн цалинг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Боловсролын газрын дарга С.Мөнхцэцэг, нягтлан бодогч Г.Тунгалаг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 04

Дугаар 57/А2370448  
ХЭА-2022/21/НА-СТА-7113

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ахмадын санд төлөвлөгдөөгүй 5.4 сая төгрөгийг шилжүүлсэн.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 197 дүгээр тогтоолоор батлагдсан "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам"-ын 2 дугаар хавсралтын 1.1.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлийн саналыг үндэслэн өөрийн төсөв, жил бүрийн үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулна.", 1.3-т "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана." гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын газрын дарга С.Мөнхцэцэг, нягтлан бодогч Г.Тунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА



Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

023040191



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 04

Дугаар 52/А2370448  
Х7А-2022/21/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсролын газрын дарга өөрийн нөхрийг байгууллагын жолоочийн албан тушаалд 2021 оны 11 дүгээр сард томилж, 2.0 сая төгрөгийн цалин, томилолт олгосон.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно." гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын газрын дарга С.Мөнхцэцэг, нягтлан бодогч Г.Тунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА



Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймагийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

023040185



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 04

Дугаар 53/А2370448  
ХЭА-2022/21/НА - СТА -ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэлт төсвийг хэмнэж ажиллах арга хэмжээ аваагүйгээс 34.2 сая төгрөгийг сургалтын багшийн хөлс, хоол, цайны материал, шатахуун, томилолт, уралдаан тэмцээний шагналд зарцуулсан.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын газрын дарга С.Мөнхцэцэг, нягтлан бодогч Г.Тунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

2317144297  
СНСА0046 9074082

023040205



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 04

Дугаар 54/А 2370448  
ХЭА - 2022/21/НТ - СТА - ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин 3.8 сая төгрөг зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын газрын дарга С.Мөнхцэцэг, нягтлан бодогч Г.Тунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА